



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өгийнуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/011/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)

Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)

Ахлах аудитор Н.Энхчимэг

Утас: 7033-3019

Цахим хаяг: [Enkhchimeg@audit.gov.mn](mailto:Enkhchimeg@audit.gov.mn)

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 165  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ш.ҮҮРЦАЙХ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өгийнуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сангаас 2015 онд олгосон 20 зээлдэгчтэй холбоотой 28,935.2 мянган төгрөг, ХЭДС-аас олгосон 6 зээлдэгчтэй холбоотой 11,874.2 мянган төгрөг нийт 40,809.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн, 11 жилийн насжилттай зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Тайлант оны Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй 8,978,9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361

дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,379,233.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,895,317.6 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 483,915.9 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Өгийнуур сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 13 үндсэн зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 69.3 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	759,712.35	909,155.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	500,213.66	701,415.11
33	АВЛАГА	162,002.41	95,403.86
34	БАРАА МАТЕРИАЛ	64,220.78	65,462.08
35	НӨӨЦИЙН БАРАА	33,275.5	46,874.25
36	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,596,371.46	1,588,790.59
2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,596,371.46	1,588,790.59
39	Биет хөрөнгө	1,547,572.06	1,539,991.19
3	Биет бус хөрөнгө	48,799.4	48,799.4
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,356,083.81	2,497,945.9
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	16,657
5	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	16,657
51	03 Өглөг	0	16,657
51200	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,356,083.81	2,481,288.9
51210	Засгийн газрын хувь оролцоо	2,356,083.81	2,481,288.9
51220	Засгийн газрын оруулсан капитал	433,914.4	433,914.4
51300	Хуримтлагдсан үр дүн	1,686,186.3	1,811,391.39
6	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	235,983.11	235,983.11
1	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,356,083.81	2,497,945.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,158,286.68	2,081,586.18
11	03 ТАТВАРЫН ОРЛОГО	626,857.16	645,429.14
110	Орлогын албан татвар	531,221.39	475,860.24
1100	Хувь хүний орлогын албан татвар	530,940.89	517,828.85
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-42,178.49
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	280.5	209.88
113	Хөрөнгийн албан татвар	52,074.71	74,260.69
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,561.06	95,308.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	259,003.87	1,436,157.04
120	Тусламжийн орлого	0	1,227,908.88
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,272,425.65	0
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,686,216.43	1,885,535.4
II	УРСГАЛ ЗАРДАЛ	1,686,216.43	1,885,535.4
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,601,866.56	1,851,014.38
210	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,480.33	853,263.45
2101	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,195.13	106,114.11
2102	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,365.04	464,497.32
2103	Хангамж, бараа материалын зардал	39,865.7	54,140.21
2104	Эд хогшил, урсгал засварын зардал	47,534	81,202.9
2106	Томилолт, зочны зардал	17,666	17,093.5
2107	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,363.69	17,258.78
2108	Бараа үйлчилгээний бусад зардал	274,396.65	257,444.1
2109	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,349.87	34,521.02
213	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	472,070.25	196,050.79
22	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	285,609.48	70,845.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-285,609.48	-70,845.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	186,460.77	125,205.09

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,989,070.66	2,113,586.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	626,857.16	645,429.14
110	Орлогын албан татвар	531,221.39	475,860.24
1100	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,000.00	-42,178.49
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	280.5	209.88
113	Хөрөнгийн албан татвар	52,074.71	74,260.69
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,561.06	95,308.21
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,260.59	40,805.22
1181	Газрын төлбөр	5,328.15	36,437.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	17,972.32	18,065.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,787.85	1,468,157.4
120	Нийтлэг татварын бус орлого	89,787.85	96,904.03
122	Тусламжийн орлого	0	1,227,908.88
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	143,344.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,272,425.65	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,536,181.53	1,740,762.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,536,181.53	1,740,762.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,451,831.65	1,706,241.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,480.33	853,263.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,195.13	106,114.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,365.04	464,497.32
2104	Хангамж, бараа материалын зардал	34,688.7	40,810.26
2106	Норматив зардал	0	2,288
2107	Эд хогшил, урсгал засварын зардал	50,953.4	82,897.9
2108	Томилолт, зочны зардал	17,666	17,093.5
2109	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,363.69	17,258.78
213	Бараа үйлчилгээний бусад зардал	126,119.35	122,017.75
III	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,349.87	34,521.02
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	452,889.13	372,824.44
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	340,868.48	171,623
VI	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	340,868.48	171,623
23	Дотоод эх үүсвэрээр	340,868.48	171,623
VII	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-340,868.48	-171,623
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	112,020.65	201,201.44
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	388,193.01	500,213.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500,213.66	701,415.11

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,169,623.05	2,169,623.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,582.41	1,582.41
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,171,205.45	2,171,205.45
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,582.41	-1,582.41
9	Тайлант үеийн үр дүн	186,460.77	186,460.77
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,356,083.81	2,356,083.81
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,356,083.81	2,356,083.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,356,083.81	2,356,083.81
19	Тайлант үеийн үр дүн	125,205.09	125,205.09
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,481,288.9	2,481,288.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

0	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө-нийт устгалын дараах	Гүйцэтгэл-нийт устгалын дараах	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	689,036,800.00	742,333,169.00	53,296,369.00	108
11	Татварын орлого	573,036,800.00	645,429,143.00	72,392,343.00	113
110	Орлогын албан татвар	458,988,000.00	475,650,362.00	16,662,362.00	104
1100	Хувь хүний орлогын албан татвар	502,790,000.00	517,828,852.00	15,038,852.00	103
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,000,000.00	-42,178,490.00	1,821,510.00	96
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	198000	209880	11,880.00	106
113	Хөрөнгийн албан татвар	70,805,500.00	74,260,687.00	3,455,187.00	105
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,243,300.00	95,308,214.00	52,064,914.00	220
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	21,704,200.00	40,805,215.00	19,101,015.00	188
1181	Газрын төлбөр	3,366,700.00	36,437,299.00	33,070,599.00	1082
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,172,400.00	18,065,700.00	-106,700.00	99
12	Татварын бус орлого	116,000,000.00	96,904,026.00	-19,095,974.00	84
120	Нийтлэг татварын бус орлого	116,000,000.00	96,904,026.00	-19,095,974.00	84
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,379,233,500.00	1,895,317,613.00	-483,915,887.00	80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,549,000.00	1,689,857,803.00	1,479,308,803.00	803
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,826,258,100.00	1,659,539,883.00	-166,718,217.00	91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	877,879,400.00	853,263,452.00	-24,615,948.00	97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,697,400.00	106,114,110.8	-3,583,289.23	97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	508,175,400.00	464,497,319.7	-43,678,080.32	91
2104	Хангамж, бараа материалын зардал	69,339,300.00	39,447,864.00	-29,891,436.00	57
2105	Норматив зардал	2,500,000.00	2,288,000.00	-212,000.00	92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,814,700.00	140,175,200.00	-31,639,500.00	82
2107	Томилолт, зочны зардал	23,730,000.00	17,093,500.00	-6,636,500.00	72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,886,200.00	30,167,697.00	-18,718,503.00	62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,933,100.00	112,606,850.00	-11,326,250.00	91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,899,000.00	30,317,919.90	-53,581,080.10	36
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,970,000.00	4,695,700.00	-9,274,300.00	34
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,929,000.00	25,622,219.90	-44,306,780.10	37
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	258,179,000.00	99,345,700.00	-158,833,300.00	38
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,200,000.00	0.00	-101,200,000.00	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	23	-3.00	88

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,067,484.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,067,484.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,864,384.00
2108	хангамж бараа материал	1,362,400.00
2109	шуудан холёоо,интернетийн төлбөр	150,000.00
	бараа үйлчилгээний бусад зардал	9,410,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,247.65

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,247.65
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>17,067,484.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,067,484.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн тусгай сангийн аудитаар илэрсэн 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 49,788.3 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 35,688.5 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

**3.1.1** Тус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэлээрх авлагын үлдэгдлийн дүн нь хоршоо хариуцсан мэргэжилтний бүртгэлээс 40,809,424 төгрөгөөр зөрүүтэй, малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Хоршоо хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэлээрх авлагын үлдэгдлийг Хоршоо хөгжүүлэх сангийн мэргэжилтний системийн бүртгэлтэй тулган шалгах ажлын хэсгийг томилж, бүртгэлийн зөрүүг арилган зээлдэгч нартай зээлийн үлдэгдлийг тулган баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах

**3.1.2** Тайлант оны Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг тулган шалгахад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй, сумын Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний бүртгэл тооцооны программын дүнгээс 8,978,884 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Хоршоо хөгжүүлэх сангийн бүртгэлийг нягтлан шалгах ажлын хэсэг томилж бүртгэлийг 2 системд ижил дүнгээр бүртгэж тайлагнах, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авах

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	1	49,788.30			1	49,788.30		
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1</b>	<b>49,788.30</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>49,788.30</b>	<b>0</b>	<b>0</b>

#### ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	91,599.50			3	91,599.50		
ОНХС	2	95,945.00			2	95,945.00		
ХХС	2	37,967.30			2	37,967.30		
<b>НИЙТ ДҮН</b>	<b>7</b>	<b>225,511.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>7</b>	<b>225,511.8</b>	<b>0</b>	<b>0</b>